



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/269

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нарийнтээл сумын Баянтээг багт баригдсан Шахмал түлшний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажил дууссан тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга, байгууламжийг ашиглалтад оруулах, дүгнэлт гаргах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0513

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дүгээр
сарын-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт

ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлстийн дарга)

Гишүүд:

С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Б.Даваацэрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Б.Балжинням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Ахмад)

Т.Ариунаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Б.Сугар (Нарийнтээл сумын Засаг дарга)

О.Төмөр (Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын инженер)

Ашиглагч:

Д.Азбилэг ("Баянтээг түлш" ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирал)

Гүйцэтгэгч:

Б.Ганзориг ("Баялаг-Эрдэнэ цом" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)